

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2015 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2015.05.20

Улаанбаатар хот


НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

2015 оны I улирлын байдлаар нийт 207 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.


ХЗХ-дыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо		
		2013 онд	2014 онд	2015 оны I улирал
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	141	159	207
	Үүнээс:			
2	Төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	2	22	71
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	-	1	1
4	Салбарын зөвшөөрөлтэй	1	4	4

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:



ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:



ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант улиралд нийт 207 ХЗХ нэгтгэлд хамрагдахаас 98.5 хувь буюу 204 ХЗХ-ны тайлан нэгтгэлд хамрагдлаа:¹

Нэгтгэлд хамрагдсан 204 ХЗХ-ны 12 ХЗХ тайлан мэдээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хороонд огт ирүүлээгүй. Энэ нь төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй ХЗХ-д бөгөөд эдгээрийн тайланг Хорооноос тусгай зөвшөөрөл авах үед ирүүлсэн эхлэлтийн балансар хянан шалгагч нар шивж оруулан нэгтгэлд хамрууллаа. Үүнд:

№	ХЗХ-ны нэрс	Байршил	Нийт актив /төгрөгөөр/
1	Алтан сонголт	БЗД, 22-р хороо	1,500,000
2	Арвижих оргил хайрхан	СХД, 25-р хороо	2,655,000
3	Ирээдүйн саятан	БЗД, 4-р хороо	4,600,000
4	Хужиртайн булгийн ундрага	Багануур, 2-р хороо	2,600,000
5	Хэтийн заяатай хан-уул	ХУД, 6-р хороо	2,500,000
6	Дэвшил баянзүрх-7	БЗД, 7-р хороо	700,000
7	Итгэлт баян өргөө	СХД, 19-р хороо	270,000
8	Өнөр сүлд	СХД, 12-р хороо	1,300,000
9	Дарь эх арвижих	БЗД, 21-р хороо	505,000
10	Хангайн арвин арвай	СХД, 23-р хороо	4,700,000
11	Гачуурт финанс	БЗД, 20-р хороо	6,600,000
12	Бэлх арван найм	СБД, 18-р хороо	2,500,000
			30,430,000

2.1 Гишүүдийн статистик үзүүлэлтүүд

(тоогоор)

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ ХЗХ		Улаанбаатар хотын ХЗХ		Орон нутгийн ХЗХ	
Нийт гишүүдийн тоо	32778		16093		16685	
Үүнээс: эмэгтэй	17939	55	9412	58	8527	51
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	34	0	23	0	11	0
Гишүүдийн насжилт	32778		15275		17503	
18-35 насны	8637	26	4664	31	3973	23
36-45 насны	10735	33	5121	34	5614	32
46-55 насны	8409	26	3936	26	4473	26
55-аас дээш	4963	15	1531	10	3432	20
Гишүүн хуулийн этгээд	34	0	23	0	11	0
Гишүүдийн боловсрол	32778		16211		16567	
Дээд	15377	47	10410	64	4967	30
Тусгай дунд	4642	14	2197	14	2445	15
Бүрэн дунд	6466	20	2658	16	3808	23
Дунд	3989	12	766	5	3223	19
Бага	2270	7	157	1	2113	13
Гишүүн хуулийн этгээд	34	0	23	0	11	0
Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо	14199		6328		7871	
Хугацаатай	10375	32	4058	25	6317	38
Хугацаагүй	3824	12	2270	14	1554	9

¹ Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн 2, хүчингүй болгосон 1 ХЗХ-ны үзүүлэлтүүд нэгтгэлд хамрагдаагүй болно. Хадгаламж, зээлийн хоршоодын 2015 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Зээлдэгч гишүүдийн тоо	13493	41	5118	32	8375	50
Хэвийн	12438	38	4541	28	7897	47
Хугацаа хэтэрсэн	616	2	346	2	270	2
Чанаргүй:	439	1	231	1	208	1
Хэвийн бус	155	0	54	0	101	1
Эргэлзээтэй	123	0	77	0	46	0
Муу	161	0	100	1	61	0

Тайлант улиралд нэгтгэлд хамрагдсан 204 ХЗХ-ны гишүүдийн тоо 32,778-д хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеээс 5,748-аар, 2014 оны жилийн эцсээс 2,080-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт гишүүдийн 16,685 буюу 50.9 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 81 ХЗХ-ны, 16,093 буюу 49.1 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 123 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн 13,493 гишүүн буюу нийт гишүүдийн 41.2 хувь нь зээлдэгч гишүүд байгаагаас 5,118 буюу 31.8 хувь нь Улаанбаатар хотын, 8,375 буюу 50.2 хувь нь орон нутгийн ХЗХ-д байна.

Нийт гишүүдийн 14,199 буюу 43.3 хувь нь хадгаламж эзэмшигч гишүүд эзэлж байгаагаас 6,328 буюу 39.3 хувь нь Улаанбаатар хотын, 7,871 буюу 47.2 хувь нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд²

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны I улирал	2015 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	140	207	67	47.9
2	Гишүүдийн тоо	27,030	32,778	5,748	21.3
3	Нийт актив	75,985,971.0	85,768,698.0	9,782,727.0	12.9
	Банкны салбарт эзлэх хувь	0.4	0.4	0.0	0.0
4	Нийт зээлийн үлдэгдэл	61,732,910.0	71,582,329.0	9,849,419.0	16.0
	Банкны салбарт эзлэх хувь	0.5	0.6	0.1	20.0
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,645,059.0	1,965,428.0	320,369.0	19.5
	Банкны салбарт эзлэх хувь	0.3	0.3	0.0	0.0
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	52,161,375.0	56,663,428.0	4,502,053.0	8.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.7	0.8	0.1	14.3
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9,841,119.0	10,092,303.0	251,184.0	2.6
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	6,737,759.0	8,049,666.0	1,311,907.0	19.5
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	1,443,585.0	3,750,482.0	2,306,897.0	159.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	465,598.0	2,329,003.0	1,863,405.0	400.2
11	Нийт орлого	4,524,473.0	5,045,748.0	521,275.0	11.5
12	Нийт зардал	3,652,249.0	4,562,665.0	910,416.0	24.9
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	872,224.0	483,083.0	-389,141.0	-44.6

² ХЗХ-ны тоо 207 ба нэгтгэлийн тоон мэдээлэл болон санхүүгийн тайлангийн нэгтгэлд 204 ХЗХ-ны үзүүлэлт хамрагдсан.

Өмнөх оны мөн үеэс нийт ХЗХ-дын гишүүдийн тоо 21 хувиар, нийт актив 13 хувиар тус тус өссөн байна. Мөн нийт зээл болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн банкны салбарт эзлэх хувь өмнөх оны мөн үеээс 0.1 хувиар өссөн байна.

Нийт актив 9,8 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд гишүүдийн хадгаламж 4,5 тэрбум төгрөгөөр, бусдаас авсан зээлийн эх үүсвэр 4,1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 17/16 тоот тогтоолоор "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр" болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн журам"-ыг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх сангийн журад заасан шаардлагыг хангах бичил бизнесийн зээлд иргэдийг хамруулах зорилгоор Нийслэлийн хороодод ХЗХ үүсгэн байгуулах санаачилга өрнөсөнтэй холбогдуулан 2014 онд 939,500.0 мянган төгрөг, 2015 оны 1 дүгээр улиралд 1,607,500.0 мянган төгрөг нийт 30 ХЗХ-дод 2,547,400.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн эх үүсвэрийн дүн өмнөх улирлаас 2,329,897.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.

Нийт 207 ХЗХ-ны 59.9 хувь буюу 124 ХЗХ нь Улаанбаатар хотод, 40.1 хувь буюу 83 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна.



2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд³

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны I улирал	2015 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	57	124	67	117.5
2	Гишүүдийн тоо	11,909	16,093	4,184	35.1
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	44	49	5	11.4

³ Улаанбаатар хотод бүртгэлтэй нийт 124 ХЗХ байгаагаас нэгтгэлд 123 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

3	Нийт актив	65,517,074.9	73,497,239.7	7,980,164.8	12.2
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	86	86	0	0.0
4	Нийт зээлийн үлдэгдэл	53,649,415.3	61,725,702.5	8,076,287.2	15.1
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	87	86	-1	-1.1
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,392,563.4	1,369,037.9	-23,525.5	-1.7
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	85	70	-15	-17.6
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	47,213,591.6	49,260,644.1	2,047,052.5	4.3
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	91	87	-4	-4.4
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	6,805,229.8	7,039,289.3	234,059.5	3.4
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	69	70	1	1.4
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	5,587,996.7	7,412,368.4	1,824,371.7	32.6
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	83	92	9	10.8
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан богино хугацаат зээлийн дүн	1,095,755.0	3,263,601.0	2,167,846.0	197.8
10	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан урт хугацаат зээлийн дүн	77.9	1,916,181.9	1,916,104.0	2,459,697.0
11	Нийт орлого	3,675,163.8	4,047,910.1	372,746.3	10.1
12	Нийт зардал	2,970,402.2	3,729,206.3	758,804.1	25.5
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	704,761.6	318,703.7	-386,057.9	-54.8

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 123 ХЗХ-дын нийт актив 73,497,239.7 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 85.7 хувийг, орлого 4,047,910.1 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт орлогын 80.2 хувийг, зардал 3,729,206.3 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 81.7 хувийг тус тус эзэлж байна.

2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд⁴

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны I улирал	2015 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	83	83	0	0,0
2	Гишүүдийн тоо	15 121	16 685	1 564,0	10,3
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	56	50	-6	-10,7
3	Нийт актив	10 468 896,40	12 271 458,50	1 802 562,1	17,2
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	14	14	0	0,0
4	Нийт зээлийн үлдэгдэл	8 083 494,20	9 856 626,30	1 773 132,1	21,9
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	13	14	1	7,7
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	252 495,50	258 979,70	6 484,2	2,6

⁴ Орон нутагт бүртгэлтэй нийт 83 ХЗХ байгаагаас нэгтгэлд 81 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	15	13	-2	-13,3
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	4 947 783,30	6 105 921,50	1 158 138,2	23,4
	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	10	11	1	10,0
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	3 035 889,40	3 090 851,10	54 961,7	1,8
	ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	31	31	0	0,0
8	Нийт хоршоологчдын өмчийн дүнд	1 149 762,00	1 471 843,60	322 081,6	28,0
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	17	18	1	5,9
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан богино хугацаат зээлийн дүнд	348 103,00	486 880,60	138 777,6	39,9
10	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан урт хугацаат зээлийн дүнд		412 821,30	412 821,3	-
11	Нийт орлого	465 520,00	997 837,90	532 317,9	114,3
12	Нийт зардал	849 309,10	833 458,30	-15 850,8	-1,9
13	Тухайн үеийн ашиг	681 846,80	164 379,60	-517 467,2	-75,9

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 81 ХЗХ-дын нийт актив 12,271,458.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 14.3 хувийг, орлого 997,837.9 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 19.8 хувийг, зардал 833,458.3 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 18.3 хувийг тус тус эзэлж байна.

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын 2015 оны 1 дүгээр улирлын байдлаарх нийт хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:


(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2014 оны I улирал		2015 оны I улирал		Өөрчлөлт	
		Дүнд	Хувь	Дүнд	Хувь	Дүнд	Хувь
	1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	73 895 989,1	97%	83 486 614,0	97%	9 590 624,9	13%
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10 188 662,8	13%	10 203 264,2	12%	14 601,4	0%
	Бэлэн мөнгө	2 480 946,7	3%	2 557 743,7	3%	76 797,0	3%
	Банкинд байршуулсан харилцах	4 848 709,1	6%	3 055 092,0	4%	(1 793 617,1)	-37%
	Банкинд байршуулсан хадгаламж	2 859 007,0	4%	4 590 428,5	5%	1 731 421,5	61%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ						
	Арилжааны үнэт цаас	-	0%	-	0%	-	-
1.3	ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/	60 818 846,5	80%	70 070 605,7	82%	9 251 759,2	15%
	Нийт зээл	61 732 909,5	81%	71 582 328,8	83%	9 849 419,3	16%
	Хэвийн зээл	58 251 605,4	77%	67 426 126,2	79%	9 174 520,8	16%
	Хугацаа хэтэрсэн зээл	1 836 245,2	2%	2 190 774,6	3%	354 529,4	19%
	Чанаргүй зээл	1 645 058,9	2%	1 965 428,0	2%	320 369,1	19%
	Хэвийн бус зээл	662 393,7	1%	748 168,9	1%	85 775,2	13%
	Эргэлзээтэй зээл	646 352,9	1%	790 387,4	1%	144 034,5	22%
	Муу зээл	336 312,3	0%	426 871,7	0%	90 559,4	27%
	(Зээлийн эрсдэлийн сан)	914 063,0	1%	1 511 723,1	2%	597 660,1	65%
1.4	АВЛАГА	2 252 732,0	3%	2 409 664,1	3%	156 932,1	7%
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	277 811,7	0%	185 603,7	0%	(92 208,0)	-33%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1 971 955,5	3%	2 224 060,5	3%	252 105,0	13%
1.5	БУСАД ЭРГЭЛТИЙН	88 632,4	0%	223 543,4	0%	134 911,0	152%

ХӨРӨНГӨ							
	Татварын авлага	2 964,8	0%	7 529,2	0%	4 564,4	154%
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	26 651,6	0%	21 598,0	0%	(5 053,6)	-19%
	Дараа тайлангийн тооцоо	-	0%	26 657,0	0%	26 657,0	-
	Дутагдал, шамшигдал	-	0%	114 514,7	0%	114 514,7	-
	Хангамжийн зүйлс	61 980,9	0%	53 244,4	0%	(8 736,5)	-14%
	Салбар хоорондын авлага	-	0%	-	0%	-	-
1.6	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	547 115,4	1%	579 536,5	1%	32 421,1	6%
	Өмчлөх бусад хөрөнгө	549 915,4	1%	621 651,7	1%	71 736,3	13%
	(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	2 800,0	0%	42 115,2	0%	39 315,2	1404%
	2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	2 089 982,2	3%	2 282 084,3	3%	192 102,1	9%
2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	2 056 516,9	3%	2 258 212,8	3%	201 695,9	10%
	Үндсэн хөрөнгө	2 535 121,3	3%	2 764 136,5	3%	229 015,2	9%
	(Хуримтлагдсан элэгдэл)	478 604,4	1%	505 923,7	1%	27 319,3	6%
2.2	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	33 465,3	0%	8 851,5	0%	(24 613,8)	-74%
	Биет бус хөрөнгө	3 425,3	0%	14 007,0	0%	10 581,7	309%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	30 040,0	0%	5 155,5	0%	(24 884,5)	-83%
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	0%	15 020,0	0%	15 020,0	-
	Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	-	0%	15 020,0	0%	15 020,0	-
	ХӨРӨНГИЙН ДҮН	75 985 971,3	100%	85 768 698,2	100%	9 782 726,9	13%

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар буюу 9,782,726.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар буюу 9,849,419.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулбал:



3.2 Активын төвлөрлийг активын хэмжээ болон байрилаар нь авч үзвэл:

(мянган төгрөгөөр)

№	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив		Гишүүдийн тоо		Байршил	
			Дүн	Хувь	Тоо	Хувь	УБ	Орон нутаг
1	10,000,000.0 дээш	1	33,396,087,8	39%	3,129	10%	1	-
2	1,000,000.0-10,000,000.0	10	28,494,448,9	33%	6,698	20%	9	1
3	500,000.0-1,000,000.0	7	1,112,021,5	1%	2,297	7%	2	5

4	100,000.0-500,000.0	58	7,932,032,3	9%	9,654	29%	29	29
5	50,000.0-100,000.0	30	11,302,366,5	13%	6,363	19%	15	15
6	10,000.0-50,000.0	48	3,386,538,4	4%	2,914	9%	22	26
7	10,000.0 хүртэл	50	145,202,7	0%	1723	5%	46	4
	Нийт дүн	204	85,768,698,2	100%	32,778	100%	123	81

ХЗХ-дын активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 11 ХЗХ-ны нийт актив 62,078,805.3 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 72.4 хувийг, гишүүдийн тоо 8,982 байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 29.3 хувийг тус тус эзэлж байна.

Активын төвлөрлийг орон нутгийн байршлаар үзүүлвэл:

(мянган төгрөгөөр)

№	Байршил	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Активын хэмжээ	
				Дүн	Хувь
1	Улаанбаатар хот	123 ⁵	16,933	73,497,239,7	85.69%
2	Орхон аймаг	13	2,082	2,880,215,8	3.36%
3	Баян-Өлгий аймаг	5	2,988	1,781,445,7	2.08%
4	Завхан аймаг	8	1,442	1,019,265,8	1.19%
5	Хэнтий аймаг	4	1,146	1,074,354,4	1.25%
6	Архангай аймаг	3	648	874,204,2	1.02%
7	Дорнод аймаг	5	1,091	826,762,8	0.96%
8	Төв аймаг	4	574	480,048,7	0.56%
9	Өвөрхангай аймаг	2	532	563,919,5	0.66%
10	Дундговь аймаг	6	899	525,622,7	0.61%
11	Увс аймаг	4 ⁶	847	400,579,6	0.47%
12	Баянхонгор аймаг	4	1,084	388,905,8	0.45%
13	Булган аймаг	3	596	274,113,1	0.32%
14	Дорноговь аймаг	5	239	201,459,8	0.23%
15	Сүхбаатар аймаг	2	311	200,982,2	0.23%
16	Өмнөговь аймаг	3 ⁷	239	145,540,9	0.17%
17	Дархан-Уул аймаг	2	306	203,489,2	0.24%
18	Ховд аймаг	1	286	148,628,2	0.17%
19	Хөвсгөл аймаг	3	247	115,850,5	0.14%
20	Говьсүмбэр аймаг	1	62.0	104,659,8	0.12%
21	Сэлэнгэ аймаг	3	226	61,409,4	0.07%
	Дүн	204⁸	32,778	85,768,698,2	100%

Тайлант улиралд Улаанбаатар хотод нийт 124 ХЗХ байгаагаас Сүхбаатар дүүрэгт 24, Чингэлтэй дүүрэгт 25, Баянгол дүүрэгт 12, Сонгинохайрхан дүүрэгт 19, Хан-Уул дүүрэгт 15, Баянзүрх дүүрэгт 19, Налайх дүүрэгт 6, Багануур дүүрэгт 4 ХЗХ тус тус тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Орон нутгийн 21 аймгаас Говь-Алтай аймагт ХЗХ байхгүй бөгөөд бусад 20 аймагт 83 ХЗХ тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

⁵ Нийт 124 ХЗХ-ноос нэгтгэлд 123 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.


⁶ Нэр бүхий 5 ХЗХ-ноос нэгтгэлд 4 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

⁷ Нэр бүхий 4 ХЗХ-ноос нэгтгэлд 3 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

⁸ Нийт 207 ХЗХ-ноос нэгтгэлд 204 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар


Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,251,759.2 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 320,3695 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна.

Зээлийн багцыг өмнөх жилүүдтэй харьцуулбал:

(тэрбум төгрөгөөр)



Тайлант улиралд ХЗХ-дын нийт зээлийн багц 71,582,328.8 мянган төгрөг байгаа нь активын 83.0 хувийг, цэвэр зээл 70,070,605.7 мянган төгрөг буюу активын 82.0 хувийг тус тус эзэлж байна.

Нэгтгэлд хамрагдсан ХЗХ-дын тайлант улиралд олгосон, төлөгдсөн зээл дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт 204 ХЗХ	ҮҮНЭЭС:	
		Улаанбаатар хот	Орон нутаг
Зээлийн эхний үлдэгдэл	61,642,279.7	51,975,654.5	9,666,625.2
Олгосон зээл	58,557,900.9	52,706,687.7	5,851,213.2

Төлөгдсөн зээл	48,617,851.9	43,497,146.6	5,120,705,3
Зээлийн эцсийн үлдэгдэл	71,582,328.8	61,185,195.6	10,397,133,1

Тайлант улирлын эхэнд 8,777 гишүүний 61,642,279.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бол 2015 оны 1 дүгээр улиралд 204 ХЗХ-доос 6,050 гишүүдэд 58,557,900.9 мянган төгрөгийн зээл олгож, 6,854 гишүүдийн 48,617,851.9 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 11,651 гишүүний 71,582,328.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Тайлант жилд олгосон зээлийн зориулалт дараах байдалтай байна. Үүнд:

ЗОРИУЛАЛТ	НИЙТ	УЛААНБААТАР	ОРОН НУТАГ
Нийт зээл /Төгрөгөөр/	58,557,900,960	52,666,630,768	5,891,270,192
Нийт зээл /Тоо/	6,322	2,336	3,986
Иргэнд олгосон зээл /Төгрөгөөр/	30,723,312,300	24,895,338,108	5,827,974,192
Иргэнд олгосон зээл /Тоо/	6,308	2,329	3,979
Бизнесийн зээл /Төгрөгөөр/	24,085,530,764	21,599,686,252	2,485,844,512
Бизнесийн зээл /Тоо/	2,718	1,194	1,524
Үйлдвэрлэл /Төгрөгөөр/	4,379,174,827	3,642,935,248	736,239,579
Үйлдвэрлэл	742	364	378
Үйлчилгээ /Төгрөгөөр/	15,215,671,043	14,557,741,312	657,929,731
Үйлчилгээ /Тоо/	885	555	330
Газар тариалан /Төгрөгөөр/	124,621,399	60,789,660	63,831,739
Газар тариалан /Тоо/	38	16	22
Мал аж ахуй /Төгрөгөөр/	664,182,326	47,230,000	616,952,326
Мал аж ахуй /Тоо/	573	23	550
Бусад /Төгрөгөөр/	3,738,581,169	3,290,990,032	447,591,137
Бусад /Тоо/	480	236	244
Хэрэглээний зээл /Төгрөгөөр/	6,571,901,536	3,286,771,856	3,285,129,680
Хэрэглээний зээл /Тоо/	3,590	1,135	2,455
Өрхийн /Төгрөгөөр/	3,984,954,216	1,589,745,293	2,395,208,923
Өрхийн /Тоо/	2,554	758	1,796
Сургалтын төлбөр /Төгрөгөөр/	191,929,490	49,213,200	142,716,290
Сургалтын төлбөр /Тоо/	230	26	204
Бусад /Төгрөгөөр/	2,395,017,830	1,647,813,363	747,204,467
Бусад /Тоо/	806	351	455
Хуулийн этгээдэд олгосон зээл /Төгрөгөөр/	27,803,468,660	27,780,229,660	23,239,000
Хуулийн этгээдэд олгосон зээл /Тоо/	14	7	7
Үйлдвэрлэл /Төгрөгөөр/	10,000,000	10,000,000	-
Үйлдвэрлэл /Тоо/	1	1	-
Үйлчилгээ /Төгрөгөөр/	27,686,229,660	27,686,229,660	-
Үйлчилгээ /Тоо/	6	6	-
Мал аж ахуй /Төгрөгөөр/	21,289,000	-	21,289,000
Мал аж ахуй /Тоо/	7	-	7
Бусад /Төгрөгөөр/	85,950,000	84,000,000	1,950,000

Харин тайлант улирлын эцэст нийт олгосон зээлийн 52.5 хувь буюу 30,723,246.0 мянган төгрөг нь 6,308 иргэнд олгосон зээл байгаа бол 47.5 хувь буюу 27,803,468.6 мянган төгрөг нь 14 хуулийн этгээдэд олгосон зээл байна.

Мөн нийт иргэдэд олгосон зээлийн 42.5 хувь буюу 24,895,338,1 мянган төгрөг, 47.4 хувь буюу 27,780,229,6 мянган төгрөгийн зээлийг Улаанбаатар хотод олгосон байна.

**ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ,
ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)


№	Үзүүлэлт	2014 оны I улирал		2015 оны I улирал		Өөрчлөлт	
	1. ӨР ТӨЛБӨР	59 407 093,3	78.2%	67 228 097,3	78,38%	7 821 004,0	13%
1.1	ХАДГАЛАМЖ	52 161 374,9	68.6%	56 663 427,8	66,07%	4 502 052,9	9%
	Хугацаагүй	2 182 729,7	2.9%	1 308 377,5	1,53%	(874 352,2)	-40%
	Хугацаатай	49 978 645,1	65.8%	55 355 050,3	64,54%	5 376 405,2	11%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1 443 858,0	1.9%	3 750 481,8	4,37%	2 306 623,8	160%
	Банкнаас авсан зээл	1 402 981,3	1.8%	2 456 454,3	2,86%	1 053 473,0	75%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	32 815,2	0.0%	587 110,2	0,68%	554 295,0	1689%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	8 061,5	0.0%	706 917,2	0,82%	698 855,7	8669%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн тусалцаа	-	0.0%	-	0.0%!	-	0.0%
1.3	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5 336 263,0	7.0%	4 485 184,6	5,23%	(851 078,5)	-16%
	Цалингийн өглөг	-	0.0%	40 660,4	0,05%	40 660,4	100%
	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	221 381,1	0.3%	193 957,9	0,23%	(27 423,2)	-12%
	Ногдол ашгийн өглөг	1 789 114,1	2.4%	555 980,8	0,65%	(1 233 133,3)	-69%
	Санхүүгийн түрээсийн өглөг	906,5	0.0%	915,0	0,00%	8,5	1%
	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	-	0.0%	12,5	0,00%	12,5	100%
	Урьдчилж орсон орлого	70 745,2	0.1%	36 201,2	0,04%	(34 544,0)	-49%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3 174 214,7	4.2%	3 584 646,7	4,18%	410 432,0	13%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	24 493,6	0.0%	4 523,8	0,01%	(19 969,8)	-82%
	Бусад богино хугацаат өглөг	55 407,8	0.1%	68 286,3	0,08%	12 878,5	23%
1.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	465 597,5	0.6%	2 329 003,2	2,72%	1 863 405,7	400%
	Банкнаас авсан зээл	365 601,5	0.5%	325 166,4	0,38%	(40 435,1)	-11%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	99 996,0	0.1%	414 840,3	0,48%	314 844,3	315%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	-	0.0%	1 586 622,7	1,85%	1 586 622,7	100%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн тусалцаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
	Хойшлогдсон татварын өр төлбөр	-	0.0%	2 373,8	0,00%	2 373,8	100%
	2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	16 578 878,0	21.8%	18 540 601,0	21,62%	1 961 723,0	12%
2.1	ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ	9 841 119,3	13.0%	10 112 705,7	11,79%	271 586,4	3%
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	9 841 119,3	13.0%	10 092 302,8	11,77%	251 183,5	3%
	Идэвхигүй гишүүний оруулсан хувь хөрөнгө	-	0.0%	20 402,8	0,02%	20 402,8	100%
2.2	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	576 107,4	0.8%	378 229,1	0,44%	(197 878,3)	-34%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	576 107,4	0.8%	378 229,1	0,44%	(197 878,3)	-34%
2.3	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	6 161 651,3	8.1%	8 049 666,3	9,39%	1 888 015,0	31%
	Нөөцийн сан	2 439 816,7	3.2%	2 570 009,4	3,00%	130 192,7	5%

Хандив, тусламж	14 612,3	0.0%	21 050,1	0,02%	6 437,8	44%
Хадгаламж, хамгаалалтын сан	180 745,0	0.2%	730 746,1	0,7%	550 001,1	304%
Нийгмийн хөгжлийн сан	538 718,2	0.7%	440 431,3	1,0%	(98 286,9)	-18%
Тогтворжилтын сан	141 689,5	0.2%	560 913,5	0,7%	419 224,0	296%
Бусад сангууд	615 209,0	0.8%	833 824,4	1,1%	218 615,4	36%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	2 230 860,6	2.9%	2 892 691,5	6,7%	661 830,9	3.7%
Тайлангийн үеийн цэвэр орлого	872 223,9	1.1%	483 083,4	-8,8%	(389 140,5)	-45%
Өмнөх үеийн цэвэр орлого	1 358 636,7	1.8%	2 409 608,0	2,1%	1 050 971,3	77%
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75 985 971,3	100%	85 768 698,2	100,0%	9 782 726,9	13%

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,782,726.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 4,502,052.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар, банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 2,306,623.8 мянган төгрөгөөр буюу 160.0 хувиар, хувь хөрөнгө 251,183.5 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар, хоршоологчдын өмч 1,888,015.0 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

(тэрбум төгрөгөөр)



4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 56,663,427.8 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 66.1 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 55,355,050.2 мянган төгрөг буюу 97.7 хувь нь 10,375 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1,308,377.5 мянган төгрөг буюу 2.3 хувь нь 3,824 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

(мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь	Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо
1	10,000,000.0 дээш	1	24,755,581,1	43.7%	1275
2	1,000,000.0-10,000,000.0	6	19,804,260,6	35.0%	2797
3	500,000.0-1,000,000.0	5	3,780,720,1	6.7%	865
4	100,000.0-500,000.0	26	5,905,393,5	10.4%	3983
5	50,000.0-100,000.0	18	1,167,814,8	2.1%	1723
6	10,000.0-50,000.0	49	1,125,112,2	2.0%	2740
7	5,000.0-10,000.0	8	54,842,6	0.1%	127

8	5,000.0 хүртэл	36	69,702,7	0.1%	689
9	Хадгаламжгүй	55	0.00	0.0%	0
Нийт хадгаламжийн дүн		204 ⁹	56,663,427,7	100.0%	14199

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 48,340,561.8 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 55.8 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 55 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 26.5 хувийг эзэлж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулбал:

(тэрбум төгрөгөөр)



4.3 Бусдаас авсан зээлийн талаар

(мянган төгрөгөөр)

№	Бусдаас авсан зээл	Улаанбаатар	Орон нутаг
1	Банкнаас авсан зээл	0.0	301,853,2
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	378,181,9	112,110,2
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,538,000,0	72,917,2
Нийт дүн		1,916,181.9	486,880,6

"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-өөс Улаанбаатар хотын 23 ХЗХ 1,607,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Харин орон нутагт бусдаас зээл авсан 23 ХЗХ байгаа ба үүний 6 ХЗХ нь банк болон санхүүгийн байгууллагаас давхар зээл авсан бол 4 ХЗХ нь банк болон төсөл хөтөлбөрөөс давхар зээл авсан байна.

4.4 Хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 10,112,7057 мянган төгрөг байгаа нь нийт активын 11.7 хувийг эзэлж байна. Үүнийг интервалиар харуулбал:

(мянган төгрөгөөр)

№	Хувь хөрөнгийн хэмжээ /интервалиар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	3 544,00	3 141 613,0	31%
2	500,000.0-1,000,000.0	1	315,00	667 340,4	7%
3	100,000.0-500,000.0	17	9 982,00	2 858 563,0	28%
4	50,000.0-100,000.0	18	4 958,00	1 264 328,8	13%
5	10,000.0-50,000.0	73	9 651,00	1 865 240,4	18%
6	5,000.0-10,000.0	19	1 421,00	143 852,2	1%
7	5,000.0 хүртэл	74	2 907,00	171 767,9	2%

⁹ Нийт 207 ХЗХ-ноос нэгтгэлд 204 ХЗХ-ны тоон мэдээлэл болон санхүүгийн тайлан хамрагдсан.

Хувь хөрөнгийн дүн	204	32778	10 112 705,70	100,0%
--------------------	-----	-------	---------------	--------

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулбал:

(тэрбум төгрөгөөр)



4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

Тайлант улиралд ХЗХ-дын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1,961723.0 мянган төгрөгөөр өсч 18,540,601.0 мянган төгрөгт хүрсэн. Үүнийг интервалиар харуулбал дараах байдалтай байна.

(мянган төгрөгөөр)

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалиар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	7,301,583,1	39.4%
3	500,000.0-1,000,000.0	4	2,806,041,5	15.1%
4	100,000.0-500,000.0	26	4,930,966,4	26.6%
5	50,000.0-100,000.0	22	1,528,434,0	8.2%
6	10,000.0-50,000.0	65	1,778,195,6	9.6%
7	10,000.0 доош	80	195,380,6	1.1%
Нийт дүн		200	18,540,601,2	100.0%

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг интервалаар харуулбал. Үүнд:

(мянган төгрөгөөр)

№	Хоршоологчдын өмчийн дүн /интервалиар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	1	2,865,098,2	35.6%
2	500,000.0-1,000,000.0	2	1,380,904,8	17.2%
3	100,000.0-500,000.0	10	2,016,607,3	25.1%
4	50,000.0-100,000.0	12	789,057,1	9.8%
5	10,000.0-50,000.0	41	931,478,3	11.6%
6	5,000.0-10,000.0	25	192,817,8	2.4%
7	1,000.0-5,000.0	26	71,519,4	0.9%
8	1,000.0 хүртэл	13	4,660,0	0.1%
9	Хоршоологчдын өмчгүй	74	-202,476,8	-2.5%
Нийт дүн		204	8,049,666,2	100.0%

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 оны I улирал		2015 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
ХҮҮГИЙН ОРЛОГО	4,411,649,4	98%	4,882,808,2	96,8%	471,158,7	10,7%
Зээлийн хүүгийн орлого	4,202,538,1	93%	4,682,822,3	92,8%	480,284,2	11,4%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	43,230,5	1%	54,800,8	1,1%	11,570,3	26,8%
Үнэт цаасны хүүгийн орлого	26,0	0%	107,4	0,0%	81,4	313,1%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	192,215,3	4%	164,004,7	3,3%	(28,210,6)	-14,7%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого (Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	1,6	0%	889,8	0,0%	888,2	55512,5%
	(26,362,1)	-1%	19,816,8	0,4%	46,178,9	-175,2%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	85,070,2	2%	92,933,8	1,8%	7,863,6	9,2%
Элсэлтийн хураамж	4,411,9	0%	8,167,5	0,2%	3,755,6	85,1%
Гишүүний татвар	10,956,6	0%	11,225,9	0,2%	269,4	2,5%
Үйлчилгээний шимтгэл, хураамж	50,209,3	1%	64,422,0	1,3%	14,212,6	28,3%
Түрээсийн орлого	7,589,0	0%	5,405,0	0,1%	(2,184,0)	-28,8%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	11,903,4	0%	3,713,3	0,1%	(8,190,0)	-68,8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	27,753,2	1%	70,006,1	1,4%	42,252,7	152,2%
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	3,6	0%	8,485,5	0,2%	8,481,9	235608,3%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	38,6	0%	139,2	0,0%	100,6	260,6%
Торгуулийн орлого	-	0%	0,4	0,0%	0,4	100%
Бусад орлого	27,710,9	1%	61,380,8	1,2%	33,669,8	121,5%
НИЙТ ОРЛОГО	4,524,472,9	100%	5,045,748,0	100,0%	521,275,1	11,5%

Тайлант улиралд ХЗХ-дын нийт орлого 5,045,748.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 521,275.1 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн байна.

Энэ нь зээлийн хүүгийн орлого 480,284.2 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар, үйл ажиллагааны бусад орлого 7,863,590.6 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар, үйл ажиллагааны бус орлого 42,252.7 мянган төгрөгөөр буюу 152.2 хувиар тус тус өссөн нөлөөлсөн байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	2014 оны I улирал		2015 оны I улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,346,047,6	64%	2,666,217,3	58%	320,169,6	35%
Хадгаламжийн хүүгийн зардал	2,333,118,7	64%	2,598,936,0	57%	265,817,3	29%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	38,461,2	1%	77,988,1	2%	39,526,9	4%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	243,1	0%	1,807,8	0%	1,564,6	0%
Бусад хүүгийн зардал	371,2	0%	1,143,7	0%	772,4	0%
(Хүүгийн зардлын буцаалт)	(26,146,6)	-1%	13,658,2	0%	39,804,8	4%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	128,936,7	4%	461,123,7	10%	332,186,9	36%
Зээлийн эрсдэлийн зардал	205,184,7	6%	428,262,6	9%	223,077,9	25%
Өмчлөх бусад хөрөнгийн	-	0%	39,191,1	1%	39,191,1	4%

үнэлгээний хасагдуулгын зардал (Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	(76,247,9)	-2%	6,330,0	0%	82,577,9	9%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,069,901,9	29%	1,332,641,8	29%	262,739,8	29%
Боловсон хүчний зардал	652,235,1	18%	843,956,7	18%	191,721,6	21%
Бусад төрлийн зардал	417,666,8	11%	488,685,0	11%	71,018,2	8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	13,299,7	0%	16,758,8	0%	3,459,2	0%
Торгуулийн зардал	96,0	0%	608,0	0%	512,0	0%
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	-	0%	12,788,1	0%	12,788,1	1%
Үйл ажиллагааны бус бусад зардал	13,203,6	0%	3,362,7	0%	(9,840,9)	-1%
Татварын зардал	94,062,9	3%	85,922,9	2%	(8,140,0)	-1%
НИЙТ ЗАРДАЛ	3,652,248,9		4,562,664,6	100%	910,415,6	100%

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 4,562,664.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 910,415.6 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар өссөн байна.

Үүнд хүүгийн зардал 320,169.6 мянган төгрөгөөр буюу 35.0 хувиар, үйл ажиллагааны зардал 262,739.8 мянган төгрөгөөр буюу 29.0 хувиар, зээлийн эрсдэлийн зардал 332,186.9 мянган төгрөг буюу 25.0 хувиар өссөн үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

5.3 Ашигт ажиллагааг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Тайлант улиралд 109 ХЗХ 1,143,973.1 мянган төгрөгийн ашигтай, 29 ХЗХ ашиг, алдагдалгүй, 66 ХЗХ 177,806.2 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 483,083.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба салбарын активын өгөөж 4.9 хувь байна.

Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 100,449.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг интервалиар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

№	Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ	Активын өгөөж
1	100,000.0 дээш	2	297 892,7	45,1%	41 208 059,9	0,7%
2	50,000.0-100,000.0	1	54 815,3	8,3%	2 290 147,4	2,4%
3	10,000.0-50,000.0	9	132 092,1	20,0%	5 099 659,3	2,6%
4	5,000.0-10,000.0	12	83 781,3	12,7%	5 188 256,9	1,6%
5	1,000.0-5,000.0	34	73 595,9	11,1%	6 687 003,4	1,1%
6	1,000.0 хүртэл	50	18 712,3	2,8%	4 260 981,0	0,4%

7	Ашиг, алдагдалгүй	29	0,00	0,0%	151 267,1	0,0%
Нийт дүн		137	660 889,7	100,0%	64 885 375,2	1,0%

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 66 ХЗХ тайлант жилд 161,842.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь нийт ашгийн 50.7 хувийг эзэлж байна

5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нэгтгэлд хамрагдсан 204 ХЗХ-дын 32.3 хувь буюу 66 ХЗХ 177,806.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

№	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо		Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
		УБ	Орон нутаг		
1	10,000.0 дээш	3	0	-84,698.0	77.6%
2	5,000.0-10,000.0 хүртэл	4	0	-28,278,1	
3	1,000.0-5,000.0 хүртэл	19	6	-40,768,7	19.0%
4	1,000.0 хүртэл	28	6	-25,061.4	3.4%
Нийт дүн		54	12	-177,806.2	100%

Өмнөх оны мөн үед 27 ХЗХ 67,175.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байсан бол тайлант улиралд 66 ХЗХ-д 177,806.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх оны мөн үетэй харицуулахад 110,631.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь 2014 оны сүүлээр болон тайлант улиралд тусгай зөвшөөрөл авсан 49 ХЗХ-д үйл ажиллагаа явуулж эхлээгүй буюу орлого олоогүй үүсгэн байгуулагдаж тусгай зөвшөөрөл авахтай холбоотойгоор эхлэлтийн зардлууд гарсан нь нөлөөлсөн байна.

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 54 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 133,569.0 төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 75.1 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 12 ХЗХ тайлант улиралд 44,237.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 24.9 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2014 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ /ДМҮ	ХАНГААГҮЙ ТОО	ХУВЬ
А	ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ			
1	ХӨРӨНГИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (мянган төгрөг)		152	74,9%
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	22	10.8%
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	28	13.8%
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА	ДМҮ	6	130.8
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	105	51.7%
2	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	3	1.5%
3	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМҮ	19	9.4%
4	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	91	44.8%

5	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	38	18.7%
6	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	12	5.9%
7	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	98	48.3%
8	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	12	5.9%
9	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	28	13.8%
10	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	26	12.8%
В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ				
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	17	8.4%
Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР				
12	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	57	27.9%

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй ХЗХ-д дараах байдалтай байна. Үүнд:

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	53	25,9%
2	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	20	9,8%
3	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	14	6,8%
4	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	72	13,8%
5	5 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	1	3,7%
1	1 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	52	25,5%
2	2 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	27	13,2%
3	3 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	16	7,8%
4	4 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	3	1,4%
5	5 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	1	4,9%
6	6 ДМУ харьцааг хангаж ажиллаагүй ХЗХ-дын тоо	1	4,9%

Салбарын хэмжээгээр зээлийн сарын дээд хүү 10%, доод хүү 1.2%, жигнэсэн дундаж хүү 2,1%-тай байгаа хэдий ч 1.6%-аар 1 ХЗХ зээл олгосон байх бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан нийт олгосон зээлийн 67.7%-ийг эзэлж байгаа тул үүнийг хасаж жигнэсэн дундаж хүүг тооцож гаргавал салбарын хэмжээгээр зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 3.0%-тай байна.

Хамгийн бага сарын хүү болох 1.2%-аар "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байгаа 30 ХЗХ зээл олгосон байна.

Хадгаламжийн хүүгийн судалгаа:

Хугацаатай хадгаламжийн сарын дээд хүү 4%, сарын доод хүү 0.6% байгаа бол хугацаагүй хадгаламжийн сарын дээд хүү 1.0%, сарын доод хүү 0.4%-тай байна. Өмнөх улирлын байдлаар салбарын хэмжээгээр татан төвлөрүүлсэн хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүүг тооцоход 1.59%-тай байсан болно.

Салбарын хэмжээгээр зээлийн сарын дээд хүү 10%, доод хүү 1.2%, жигнэсэн дундаж хүү 2,1%-тай байгаа хэдий ч 1.6%-аар 1 ХЗХ зээл олгосон байх бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан нийт олгосон зээлийн 67.7%-ийг эзэлж байгаа тул үүнийг хасаж жигнэсэн дундаж хүүг тооцож гаргавал салбарын хэмжээгээр зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 3.0%-тай байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Тайлант улиралд нийт 49 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан 49 ХЗХ нь "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилготойгоор байгуулагдсан болно.

Харин Улаанбаатар хотын "Олон зул" ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, Завхан аймгийн "Ойгоны ирээдүй" ХЗХ, Өмнөговь аймгийн "Товь инвест" ХЗХ-дын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд ХЗХ-дын тайланг хамрагдсан байдлыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 2011 онд 93.8 хувь, 2012 онд 96.0 хувь, 2013 онд 97.2 хувь, 2014 онд 95.0 хувь, 2015 онд шинээр байгуулагдсан хороодын 12 ХЗХ-ны тайлан огт ирүүлээгүйг эхлэлтийн тайлангаар нэгтгэлд хамруулснаар 98.5 хувийн ирцтэй байна.

1. Нийт актив

Тайлант улиралд ХЗХ-дын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,782,727.0 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өсөж, 85,768,698.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.4 хувьтай тэнцэж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 4,184-өөр өсч, нийт актив 7,980,164.8 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар, орон нутгийн ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 1,564-өөр өсч, нийт актив 1,802,562.1 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар тус тус өссөн байна.

2. Нийт зээлийн үлдэгдэл

Нийт зээлийн үлдэгдэл 71,582,329.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.6 хувьтай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 9,849,419.0 мянган төгрөгөөр буюу 16.0 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 320,369.0 мянган төгрөг буюу 19.0 хувиар тус тус өссөн байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

Нийт хадгаламжийн үлдэгдэл 56,663,428.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.8 хувьтай тэнцэж байна. Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеээс 4,502,053.0 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн ба нийт мөнгөн хадгаламжийн 97.7 хувь нь хугацаатай, 2.3 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 251,183.5 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар өсч, гишүүдийн тоо 5,748-аар нэмэгдсэн байна. Нийт хувь хөрөнгө тайлант улиралд 10,112,705.7 мянган төгрөг байгаа ба үүний 99.8 хувь буюу 10,092,302.8 мянган төгрөг нь идэвхтэй гишүүний хувь хөрөнгө бол 0.2 хувь буюу 20,402.8 мянган төгрөг нь идэвхигүй гишүүний хувь хөрөнгө байна.

5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеээс 1,888,015.0 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт бөгөөд тайлант улиралд 2,892,691.5 мянган төгрөгийн хуримтлагдсан орлоготой байгаа нөлөөлсөн.

6. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 521,275.1 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар, нийт зардлын хэмжээ 910,415.6 мянган төгрөгөөр буюу 24.9 хувиар тус тус өсч тайлант үеийн цэвэр орлого 483,601.4 мянган төгрөг байна.

Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 388,622.5 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 49 ХЗХ байгуулагдан үйл ажиллагааны зардал гарсан болон хадгаламжийн хүүгийн зардал, зээлийн эрсдэлийн зардал өндөр гарсан нь нөлөөлсөн байна.

7. Зохистой харьцааны үзүүлэлт

Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан 44 ХЗХ байгаа ба эдгээр нь нийт ХЗХ-дын 21.5 хувийг эзэлж байна.

Харин зохистой харьцааны 1 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй 53 байгаа нь нийт ХЗХ-дын 26.0 хувийг, 2 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй 20 байгаа нь нийт ХЗХ-дын 9.8 хувийг, 3 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй 14 байгаа нь нийт ХЗХ-дын 6.8 хувийг, 4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй 42 байгаа нь нийт ХЗХ-дын 20.6 хувийг тус тус эзэлж байна.

Хугацаатай хадгаламжийн сарын дээд хүү 4%, сарын доод хүү 0.6% байгаа бол хугацаагүй хадгаламжийн сарын дээд хүү 1.0%, сарын доод хүү 0.4%-тай байна. Салбарын хэмжээгээр татан төвлөрүүлсэн хугацаатай хадгаламжийн жигнэсэн сарын дундаж хүү 1.59%-тай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР